



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/158

Мандалговь

Өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 6 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.1, 2.2 үндэслэн ТУШААХ нь.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэрийн  
Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ахлах  
мэргэжилтэн

Гишүүд: Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан  
мэргэжилтэн

Мэдээллийн технологийн ажилтан

Нягтлан бодогч

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого

төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалтын

гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн

Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж,

системчлэл, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

Үйлчилгээний албаны дарга

2. Зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавихдаа хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах, Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгахыг Өмч хамгаалах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Л. ДОРЖБАТ



150411